

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ЯАМНААС 2009 ОНЫ 06 ДУГААР САРД  
ХИЙСЭН ГОЛ АЖИЛ**

**Нэг. Бодлого төлөвлөлтийн асуудлаар:**

1. Улсын Их Хурал болон Байнгын хороодын хурлаар хэлэлцүүлсэн асуудал:

- “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуульд өөрчлөлт оруулж, малчин өрхийг орлогын албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг 2009 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.
- Малчдын талаар төрөөс баримтлах бодлогын төслийг, УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-ын 2009 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 39 тоот тогтоолоор батлуулав.
- “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төслийг 2009 оны 06-сарын 25-ны өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулж, хуулийн төслийг хэлэлцэхээр тогтов. Хуулийн төслийг хэлэлцүүлэхтэй холбогдуулан УИХ-аас байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж байна.

2. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудал:

- “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2009 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, 178 тоот тогтоолоор батлуулав.
- 2009-2017 онд хэрэгжүүлэх “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2009 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, 173 тоот тогтоолоор батлуулав.
- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр нөөцөлсөн шатахууныг уринш боловсруулалт, ургац хураалтанд зориулан зээлээр гаргах тухай УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг боловсруулан, Засгийн газрын нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэн 35 дугаар тэмдэглэл гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна.

3. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлууд:

- Сайдын зөвлөлийн ээлжит хуралдааныг 2009 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, хуралдаанаар:
  - “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор аж ахуй эрхэлж буй туршлагыг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай”,
  - “Бараа түүхий эдийн биржийн тухай” хуулийн төсөл,
  - "Арьс шир дэд хөтөлбөр"-ийг хэлэлцүүлж,
  - “Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийн хяналт-шинжилгээ үнэлгээний дүн,
  - “ Үхэр, хонь, ямаан сүргийн бруцеллэзтой тэмцэх төсөл”-ийн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг танилцуулан, зохих шийдвэрийг гаргуулав.

4. Судалж, боловсруулсан асуудлын талаар:

- “Стратегийн нөөцийн улаанбуудайг борлуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлэв.
- Хаврын тариалалтын эцсийн дүнгийн танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар ЗГХЭГ-т хүргүүлэв.
- Хүнсний тухай хуулийн шинэчилсэн төсөл боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 171 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулж, ажлын хэсгийн хурлыг 06

- дугаар сарын 22-нд зохион байгуулан, хуулийн төслийг 08 дугаар сард хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтлүүлж аж ахуйн нэгж, олон нийтийн санал авахаар тогтов.
- “Малчдаас мал, мах бэлтгэх, урамшуулал олгох” журмын төсөл, Засгийн газрын тогтоолын төслийн санал боловсруулж байна.
  - Дотоодын ноос, ноолуур, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, зөгийн балыг худалдан авсан этгээдийн үнэд НӨАТ шингэсэн гэж үзэж, худалдан авсан үнээс хасалт хийх асуудлыг зохицуулахаар “НӨАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг ХХААХҮ-н сайд, Сангийн сайдаар батлуулан, ХЗДХЯ-д хүргүүлэв.
  - Говь хээрийн бүсэд уст цэг ашиглан чанар сайтай тэжээлийн ургамал тариалах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх талаар төслийн баримт бичиг боловсруулав.
  - “Буудайн гурил MNS-0244:2003 Техникийн ерөнхий шаардлага” үндэсний стандартыг шинэчлэн боловсруулж, төслийг СХҮТ-ийн Ургамлын гаралтай бүтээгдэхүүний стандартчилалын Дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлэв.
  - “Хүнсний нэмэлтүүдийг улсын бүртгэлд бүртгэх, хяналт тавих журам”-ын төслийг МХЕГ-тай хамтран боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэхээр ажиллаж байна.
  - “Арьс ширний салбарын тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн төсөлд яамдуудаас ирүүлсэн саналыг нэгтгэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.
  - “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг 1/2092 тоот албан бичгээр ЗГХЭГТ-т хүргүүлэв.
  - Сав, баглаа боодол болон тэдгээрийн түүхий эдийг импортлох, үйлдвэрлэх, ашиглах, дахин боловсруулах, устгахад аюулгүй байдлын болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх үйл ажиллагааг зохицуулах, дэмжлэг үзүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөлд холбогдох яамдаас саналыг авч тусган, ЗГХЭГ-т хүргүүлэв.
  - “Хоршооны тухай” хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг ХЗДХЯ, СЯ, Хоршоодын холбоодын төлөөллийг оролцуулан байгуулж, хуулийн төслийг боловсруулж байна.
  - “Ноос” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн сайдын 123 тоот тушаалаар байгуулан, ажиллаж байна.
  - “Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр”-ийн Үндэсний зөвлөлд ажиллах бүрэлдэхүүнийг байгуулахаар холбогдох яамдаас санал авахаар хүргүүлэв.

#### **Хоёр. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудлаар:**

- “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Архангай, Булган, Сэлэнгэ, Өмнөговь аймагт НХХЯ, ХХААХҮЯ-ны хамтарсан ажлын хэсэг ажиллаж, аймгуудын 12 сумын 60 малчны бүлгийн төслүүдийг сонгон шалгаруулалт хийж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 300 сая төгрөгийн санхүүжилт олгов. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 3.2, 3.3 дахь заалт, хамтарсан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн, НХХ-ийн сайд, ХХААХҮ-ийн сайдын 93/150 тоот хамтарсан тушаалаар уг хөтөлбөрт Завхан аймгийн Их Уул, Тосонцэнгэл, Тэлмэн сумдыг нэмж хамруулан, нийтдээ 120.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас шийдвэрлүүлэв.
- Баян-Өлгий, Ховд аймагт нийт 60.0 мянган га талбайд тархсан царцаатай химийн аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулахаар аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэргийн газартай гэрээ байгуулан нийт зардлын 90 хувь буюу 243.0 сая төгрөгийн санхүүжилтийг хийж, шаардагдах ургамал хамгаалах бодис, хор шүршигч техник бүхий бага оврын тракторын иж бүрдэлийг орон нутагт олгох хуваарийг 131 дүгээр тушаалаар батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.
- ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хөдөө аж ахуйн эдэлбэр газрын асуудал хамрагдах болсонтой холбогдуулан бэлчээрийн газрын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах, бэлчээрийн менежментийн судалгааны талаарх цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах зэрэг ажлыг шуурхай болгох зорилгоор ХХААХҮ сайдын 124 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулан, хэрэгжилтийг зохион байгуулж байна.
- Газрын доорхи усны геофизикийн хайгуулын тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж, шалгарсан 3 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

- Ургамал хамгааллын бодис буюу үр тариа, төмс, хүнсний ногооны гербицид олгох хуваарийг ХХААХҮ-ийн сайдын 145 дугаар тушаалаар батлуулж, олгох ажлыг зохион байгуулж байна.
- Услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах ажлыг гүйцэтгэх эрх бүхий 23 аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн чадварын үнэлгээ болон шинээр болон сэргээн засварлах услалтын системийн төсөл сонгон шалгаруулах 4 багц тендерт ирүүлсэн төсөлд үнэлгээ хийж байна.
- Улаанбаатар хотын Хан- Уул дүүрэгт 20 га талбайд тарих 20,0 мянган ширхэг чацаргана, 15.0 мянган ширхэг үхрийн нүдний суулгацыг нийлүүлж, тарих, хашаа барих, худаг гаргах ажлыг дуусгахад дэмжлэг үзүүлж, хяналт тавин ажиллаж байна.
- Баруун бүсэд усалгаатай газар тариалан болон бэлчээрийг сэргээн хөгжүүлэх хөгжлийн стратеги боловсруулах судалгаа хийх төслийн үндэслэлийг боловсруулж, холбогдох байгууллагуудын саналыг авч нэгтгэв.
- “Хүлэмжинд хүнсний ногоо тариалах технологи” сэдэвт сургалтыг “КОЙКА” Олон улсын байгууллагатай хамтран ХХААХҮЯ дээр зохион байгуулав. Сургалтад нийслэлийн Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар дүүргийн нийт 30 гаруй ногоочид оролцов.
- ОХУ-аас зээлээр нийлүүлсэн 19 ширхэг ХАА-н техникүүдийг хүлээн авч, батлагдсан хуваарийн дагуу Беларусь-82.1 маркийн 9 ширхэг тракторыг Говь-Алтай аймгийн “Шимт газар” ХХК, Өмнөговь аймгийн “Бат-Амгалан” хоршоо, Нийслэлийн “БДЦС” ХХК, Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ тариа” ХХК, Жавхланта сумын “Агьт цэцэн тахилга” ХХК, Алтанбулаг сумын “Баян-ундрага” ХХК, Отрын бүс нутгийн захиргаа, Малын удмын сангийн үндэсний төв, Төв аймгийн Цээл сумын “Шинэ залуучууд” ХХК, Угтаал сумын “Уушиг хайрхан” ХХК-дад олгов. Түннчлэн Беларусь 1221.2 маркийн 6 тракторыг Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Мандал сум, Цагааннуур сум, Сайхан сумын “Ачитбуурагчин” ХХК, “Спирт бал бурам” ХХК, “Интосэ” ХХК, “Сэлэнгэ тариа” ХХК, “Алтанбуурал” ХХК, “Газрын ундраа” ХХК-иудад олгов. ВМТЗ 2032 А маркийн 2 ширхэг тракторыг Говь-Алтай аймгийн “Шимт газар” ХХК, Нийслэлийн Хан-Уул дүүргийн “Хасу-Холдинг” ХХК-д тус тус олгов. Мөн ОХУ-аас зээлээр нийлүүлэгдэж байгаа трактор, ХАА-н чиргүүл дүүжин машиныг хүлээн авах, хадгалах, техникийн үйлчилгээ, баталгаат хугацааны засвар хийх чиглэлээр “Агромаштех” ХХК-тай гэрээ байгуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. “Техник тоног төхөөрөмж зээлээр олгох тухай” ХХААХҮ-ийн Сайдын 2009 оны 143 дугаар тушаалаар ОХУ-аас беларус-1221.2 трактор 99ш, беларус 826 трактор 48ш, ВТЗ 2032А трактор 46ш, анжис, сийрүүлүүр тус бүр 30ш, үрийн буудай 5815 тн-ийн ачуулах хүлээн авах ажлыг ОХУ-ын Рос Агро Лизинг ХК-тай хамтран ажиллаж, 80 морины хүчтэй беларус трактор 36, 30 м/х-тэй трактор 2, 130 морины хүчтэй трактор 48, сийрүүлүүр 30, анжис 12-ийг 59 аж ахуйн нэгжид 15-20 хувийн урьдчилгаа төлж, жилийн 13 хувийн хүүтэй 3 жилд төлөх нөхцөлтэй олгоод байна.
- Техникийн засвар үйлчилгээний газар бий болгох, сэлбэгийн хангамжийг сайжруулах зорилгоор Техник үйлчилгээний дундын төвийг 6 аймгийн 9 суманд байгуулахаар ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 142 дугаар тушаал гаргуулж, эдгээрт трактор 9 ш, комбайн 1ш, төмсний иж бүрдэл 8 ш, шүдэт борной 28 ш, анжис ПЛН-3-35 8ш, сийрүүлүүр 1ш-ийг олгоод байна.
- Жимс жимсгэний аж ахуйд дэмжлэг үзүүлэх “Төсөл шалгаруулж, дэмжлэг үзүүлэх тухай” ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2009 оны 131 дүгээр тушаалын дагуу төсөл хэрэгжүүлэхээр шалгарсан 70 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулахаар санхүүжилтийг Сангийн яамнаас эрх аван 23 аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээ хийгээд байна.
- Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, ургац нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, Засгийн газрын 2008 оны 70 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ХХААХҮ-ийн Сайдын 2009 оны 145 тоот тушаалаар 2.4 бутилийн эфир 40.000 литрийг газар тариалан эрхэлдэг 115 аж ахуйн нэгжид олгоод байна.
- Монгол, ОХУ-ын хооронд ХАА-н салбар хамтран ажиллах цогцолбор арга хэмжээний хүрээнд “Буриад-79”, “Арюна”, “Селенга” сортын нийт 5841 тонн үрийн буудай хүлээн авахаар “Технология”ООО-тай гэрээ байгуулж, хүлээн авах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд нийт 83.0 гаруй мянган га уриншид тариалалт хийх үрээр хангагдаад байна. Үүнээс үрийн шинэчлэлд зориулан 331.6 тонныг газар тариалан эрхлэж байгаа 6 аж ахуйн нэгжид гэрээ байгуулан олгов.
- “Хурын шим” ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулж, газар тариалангийн бүс нутгуудад 2 удаа үүл буудуулж, бороо оруулав. Сэлэнгэ, Булган, Төв, Хэнтий аймагт тус

- бүр 2 суурь, Хөвсгөл, Увс аймгуудад тус бүр 1 суурь байрлуулан ажиллаж байна. 05 сарын 7-10-ны өдрүүдэд үүл буудснаар газар тариалангийн бүс нутгуудаар 29,2 мм, 05 сарын 26-27 өдрүүдэд 1-20 мм тунадас орсон тухай тайланг “Хурын шим” ХХК-иас ирүүлээд байна.
- “Бөөний худалдаа” хөтөлбөрийн хүрээнд олгогдсон хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах арга хэмжээг зохион байгууож байна. Энэ ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн “Халиун-Уул” ХХК-иар 30,0 сая төгрөг төлүүлж, уг хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч, нэгтгэж байна.
  - “Сүү II” төслийн хүрээнд Хэнтий, Дорнод, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад шинээр ашиглалтад орж буй “Хэнтий сүү” хоршоо, “Гурван марал” сүүний цех, “Их халбаганат” ХХК-ийн сүү боловсруулах цех, “Найнга” ХХК, “Барууншанд” ХХК-иудын сүү боловсруулах үйлдвэрүүдийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулав.
  - Монгол улсын Тэргүүн шадар сайдаар ахлуулсан “Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил”-ийн ажлыг зохион байгуулах, хяналт, тавих үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдааныг 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж, холбогдох чиглэлээр мэдээлэл, танилцуулга хийв.
  - ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайдын 2009 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн “Орон нутагт дахь үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 132/137 тоот хамтарсан тушаалыг батлуулан хэрэгжүүлж байна. Улсын төсвийн “Хөдөлмөр эрхлэлт, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр өгөх тусламж, дэмжлэг”-ийн эх үүсвэрээс орон нутгийн ЖДҮ-ийг дэмжих хуваарийг баталсан бөгөөд аймаг тус бүрт 500 сая, Улаанбаатар хотод 7 тэрбум нийт 17,5 тэрбум төгрөгийг хөнгөлөлттэй зээлээр, 12,5 тэрбум төгрөгийг ЖДҮ-ийг хөгжүүлэх санд хувиарлагдсан хөрөнгөөс орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн хүрээнд эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц арга хэмжээг санхүүжүүлэхээр болов.
  - “Үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөлгөөн”-ийг 2009 оны 06-сарын 05, 06-ны өдрүүдэд Говьсүмбэр, 2009 оны 6-р сарын 29, 30-ны өдрүүдэд Хэнтий аймгийн ЗДТГ-тай тус тус хамтран зохион байгуулав.
  - “Ахуй үйлчилгээний жишиг төв” сэдэвт Төвийн бүсийн үзүүлэх сургалт, үзэсгэлэнг Эрдэнэт хотод 2009 оны 6-р сарын 19-ний өдөр Орхон аймгийн ЗДТГ, Монголын үйлдвэрлэлийн хоршоодын төв холбоотой хамтран зохион байгуулав.
  - “Арьс ширний салбарын өнөөгийн байдал, зах зээл” сэдэвт уулзалт семинарыг Европын Холбооны “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төсөлтэй хамтран зохион байгуулж, 60 гаруй хүн хамрагдаж, мөн Өвөрхангай аймагт 4 сумын Засаг дарга, малчдыг оролцуулсан “Ноос, ноолуурын түүхий эд бэлтгэлийн чанарыг сайжруулах нь” сургалт, ярилцлагыг зохион байгуулан, 30 гаруй хүн хамрагдав.
  - Хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр хэрэгжүүлсэн шинжлэх ухаан, технологийн төслийн тайланд үнэлэлт, дүгнэлт гарган яамны дэргэдэх шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэв.
  - Шувууны томуу, гахайн ханиад гарсантай холбогдуулан 22 аймагт ариутгал халдваргүйтгэлийн талаар зөвлөмж, авах арга хэмжээний заавар боловсруулан хүргүүлэв. Япон улс руу шувууны томуу өвчний шинжилгээнд дээж илгээж, батлагдсан тул сэг зэмийг устгаж, ариутгал халдваргүйтгэлийг бүрэн хийж дуусгав. Одоогийн байдлаар хорио цээрийг татан буулгаж, уг өвчнөөр тайван байна.
  - Орхон, Дархан-Уул, Сүхбаатар, Завхан аймгийн 78 малын эмч нарыг бруцеллёзын шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулав. /Баян-Өлгий аймгийн малын эмч нараас бусад аймгийн малын эмч нар бүрэн хамрагдсан байна./
  - “Малын цусны паразит өвчний тандалт”, “Паразит өвчнийг эмчлэх зарим бэлдмэлийн малын биед дасан зохицол” судалгаа шинжилгээний ажлыг Хэнтий, Дундговь, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Өвөрхангай, Баянхонгор аймагт хийхээр төвлөвлөж, судалгааны ажлыг Дундговь аймагт эхлүүлээд байна.
  - Багахайрханы отрын нутагт 1 га талбайд царгас, Аргалантын отрын бүс нутагт 6 га талбайд овъёос, Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутагт 50 га талбайд царгас, хөх тариа, тариалж хашиж хамгаалах ажлыг бүрэн дуусгалаа.
  - Төв аймгийн Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутгийн бэлчээрийг 2 жилийн хугацаанд өнжөөхтэй холбогдуулан Засгийн газрын 2009 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 265 дугаар тогтоол гаргуулан, хэрэгжилтийг зохион байгуулж байна.
  - Зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээг Дархан-Уул аймгийн Дархан, Орхон, Хэнтий аймгийн Дадал, Дорнод аймгийн Баяндун, Хөвсгөл аймгийн Тариалан сумдад тус бүр нэг, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд нэг бүгд 6 явуулын цэгийг нээн ажиллуулж, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран Увс аймгийн Улаангом хотын хүн амыг цаашид

сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор сүүний чиглэлийн арвин ашиг шимт бухны гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажлаар мэргэшсэн техникчийг томилон ажиллуулж байна. Өссөн дүнгээр 2009 он гараад гүн хөлдөөсөн үрээр 1433 үнээнд зохиомол хээлтүүлэг хийгээд байна.

- Сүүний үхрийн гарвал ашиг шимийн мэдээллийн санд бүртгэлттэй 198 аж ахуйн 2237 үнээнд хяналтын саалт хийж, мэдээллийг санд бүрэн оруулав. Мөн “Малын үржлийн ажлыг шинэчлэн сайжруулах” төсөлд хамрагдсан Улаанбаатар хот, төвийн бүсийн саалийн аж ахуйн үхрийн амьдын жинг тодорхойлох ажлыг бүрэн гүйцэтгэж мэдээллийн санд орууллаа.

### **Гурав. Гадаад хамтын ажиллагаа болон дотоод ажлын талаар**

- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын техник, эдийн засгийн тусламжаар хэрэгжүүлэх төслийн саналыг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэв.
- Бүгд Найрамдах Болгар Улстай хамтран хэрэгжүүлэхээр тохиролцсон “Хөдөө аж ахуйн салбарын техник, тусалцааны хөтөлбөр”, “Хэрэгжилтийн хэлэлцээр байгуулах”, асуудлын хүрээнд хүлэмжийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, Болгарын талд хүргүүлэн шийдвэрлэхээр Монгол Улсын Сангийн яам болон Бүгд Найрамдах Болгар Улсын Сангийн яамны саналыг тусган, дахин боловсруулж байна.
- “Хүнсний баталгаат байдал хөтөлбөр”-ийн хүрээнд 10 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулах “Хандивлагчдын дээд хэмжээний уулзалт”-ын бэлтгэл ажлын хүрээнд хандивлагч донор орнууд болон Олон улсын байгууллагуудад урилгыг хүргүүлэх ажлыг зохион байгуулаад байна.
- Канадын Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн сайдын урилгаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд тэргүүтэй төлөөлөгчид 2009 оны 06 дугаар сарын 13-22-ны өдрүүдэд Канад Улсын Оттава, Саскатун, Рижайна зэрэг мужуудад ажиллаад ирэв. Айлчлалын талаарх илтгэх хуудсыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна.
- Израйлын “МАШАВ” байгууллагатай хамтран “Хүлэмжийн аж ахуйн менежмент” сургалтыг Хөдөө аж ахуйд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв дээр 06 дугаар сарын 15-19-ны өдрүүдэд зохион байгуулав.
- Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Хөдөө аж ахуй, ойн сайд тэргүүтэй төлөөлөгчдийн 06 дугаар сарын 3-8-ний өдрүүдэд Монгол Улсад хийсэн айлчлалыг зохион байгуулав. Монгол Улсын Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Хөдөө аж ахуй, ойн яам хооронд хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлолын Санамж бичигт гарын үсэг зурав.
- Япон Улсын “ЖАЙКА” Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Газар тариалан, мал аж ахуйн хосолсон загвар аж ахуйн хөгжлийг дэмжих төсөл”-ийн хүрээнд хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж иргэдийн дунд сургалт зохион байгуулав.
- БНСУ-ын “КОЙКА” байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Халх голын бүс нутагт хөдөө аж ахуйг сэргээн хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн явцын тайлангийн үйл ажиллагаатай танилцах арга хэмжээг Дорнод аймагт зохион байгуулав.
- Монгол Улсын ХХААХҮ-ийн салбараас Япон Улсын Засгийн газрын 2010-2011 оны санхүүгийн жилд тавих төслүүдийн саналыг Японы талтай зөвшилцөн, Сангийн яаманд уламжлав.
- Бүгд Найрамдах Турк Улсын Техникийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдах 2009 оны сургалтанд ХХААХҮ-ийн чиглэлийн мэргэжилтнүүдийн нэрийг дэвшүүлж анкетын хамт Сангийн яаманд хүргүүлэв.
- Дор дурдсан хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийв. Үүнд:
  - Усны үндэсний хөтөлбөр,
  - “Ногоон алт” бэлчээрийн экосистемийн удирдлага хөтөлбөр,
  - НҮБ-ийн ХХААБ-ын санхүүжилттэй “Сүүний хангамжийг нэмэгдүүлэх” II төсөл,
  - Францын тусламжийн сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц.

### **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**